



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/А.

Хэрлэн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь заалтууд, Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолоор шинээр төрсөн хүүхдэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгож бүртгэх асуудлыг зохицуулсан байх тул аймгийн Засаг даргын 2008 оны 38 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 38 дугаартай захирамжид хүчингүй болгосон тэмдэглэгээг зохих журмын дагуу хийж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн улсын нэгдсэн сангийн бүртгэлээс хасуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА